



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/626

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03, 2021 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дөргөн сумын Амгаланг үүсгэгч майдрын гэгээний хийдийг сэргээн засварлах зардалд 3 000 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд зарцуулагдах 3 000 000 төгрөг /гурван сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.5 дахь "Олон үндэстэн ястны өв соёл" дэд хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дүгээр сарын 01-ний өдрийн
А/626 дугаар захирамжийн хавсралт



ДӨРГӨН СУМЫН АМГАЛАНГ ҮҮСГЭГЧ МАЙДРЫН ГЭГЭЭНИЙ
ХИЙДИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ЗАРДЛЫНТООЦОО

Д/д	Материалын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цемент	15 уут	16 000	240 000
2	Эмульс /хар цагаан/	8 уут	18 000	144 000
3	Будаг	100 литр	6 000	600 000
4	Хадаас	20 кг	6 000	120 000
5	Боронк	20 кг	7 000	140 000
6	Шил	1 авдар	300 000	300 000
7	Маанийн хүрд	4 ширхэг	364 000	1 456 000
	Дүн			3 000 000

-оОо-